



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 16 өдөр

Дугаар А/510

Номгон


Хөрөнгө гаргах тухай

Коронавирус (COVID-19)-ийн цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг эрчимжүүлэх, сумдын халдварт өвчинтэй тэмцэх бэлтгэл, бэлэн байдлыг хангах зорилгоор Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “в”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар бүлгийн 2.1.1, 2.1.2, 3 дугаар бүлгийн 3.3, Онцгой комиссын 2021 оны 58 дугаар хурлын тэмдэглэлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвчтөн тээвэрлэх автомашингүйн улмаас үүрэг гүйцэтгэх боломжгүй болсон Баянговь, Баянлиг, Өлзийт, Жаргалант сумдын Эрүүл мэндийн төвүүдийн эрсдэл бүхий онцгой нөхцөл байдлыг үнэлж, нийлүүлэх хуулийн этгээдийг шууд сонгон шалгаруулж, автомашины парк шинэчлэлтийг хийж, сум тус бүрт олгох ажлыг шуурхай зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т үүрэг болгосугай.

2.Дээрх ажлыг зохион байгуулахтай холбогдон гарах зардалд шаардагдах 180.000.000 (Нэг зуун наян сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

601210179